



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар 01256

Улаанбаатар хот

**“Монгол-Оросын хамтарсан сургууль”-ийн
данс бүртгэлээс эргэлтийн бус хөрөнгө
хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 57,812,430.0 /Тавин долоон сая найман зуун арван хоёр мянга дөрвөн зуун гучин/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг “Монгол-оросын хамтарсан сургууль” /Ж.Соронзон/-д зөвшөөрсүгэй

2. Данснаас хасагдаж буй нийт 57,812,430.0 /Тавин долоон сая найман зуун арван хоёр мянга дөрвөн зуун гучин/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг “Монгол-оросын хамтарсан сургууль” /Ж.Соронзон/-д үүрэг болгосугай.


3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 07 сарын
 10... өдрийн 01655 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Монгол-Оросын хамтарсан сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	ЭБХХК-ын шийдвэр
1	Ном, сурах бичиг	9-12	ш	16,836		57,812,430	57,812,430	-	устгах
Ном, сурах бичгийн дүн						57,812,430		-	
Үүнээс :									
Татан төвлөрүүлэх хөрөнгө									0
Устгах хөрөнгө									57,812,430